ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХЭЛТСИЙН ДАРГА
ӨЛЗИЙДҮҮРЭНГИЙН ЦОЛМОНГИЙН 2024 ОНЫ
ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

## Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

| д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин | Эхэлсэн дууссан хугацаа | Биелэ ийн ху |
| | 1 | 2 | 3 | | 4 | 5 | 6 |
| **Зорилт 1. "Олон улсын хууль ёсны худалдааг хөнгөвчлөх, түүний аюулгүй байдлыг хамгаалах"** | | | | | | | |
| 1 | Олон улсын гаалийн чиглэлээр хэрэглэж буй баримт бичгийг судлаж, боловсруулсан байдал | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | 1.Монгол Улсын Худалдааг Хөнгөвчлөх Үндэсний Хороонд Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийн хэрэгжилтийг хүргүүлж 2023 онд 85.3 хувьд хүрсэн.<br>2.ГЕГ-ын 2021 онд худалдааг хөнгөвчлөх чиглэлээр хэрэгжүүлсэн ажлын тайлан, 2023 онд хэрэгжилт хангах үүрэг амлалт авсан арга хэмжээний тайлан хүргүүлж хэрэгжилтийг хանган ажилласан. | Эхний хагас жилд:<br>1.ДГБ, ДХБ-аас гаргасан бодлогын баримт бичгийг орчуулах, албан хаагчдыг мэдээллээр хангах, гаалийн байгууллагын үйл ажиллагаанд хэрэгжүүлэх. | ДГБ, ДХБ-аас гаргасан бодлогын баримт бичиг, албан бичиг, мэдээ мэдээлэл зэрэг 85 албан захидал 135 мэйл хүлээн авч орчуулан ГЕГ-ын удирдлагуудад танилцуулан холбогдох мэдээллийг албан хаагчдад CERP болон СПАРК системээр түгээж байсан.<br>Түүнчлэн олон улсын гаалийн чиглэлийн төсөл, хөтөлбөрүүдтэй хамтран ажиллаж, 73 уулзалт, форум, сургалт зохион байгуулахад оролцож, нийт 174 албан хаагчийг хамруулсан;<br>Худалдааг хөнгөвчлөх ажлын хэсгийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулахад саналаа тусгасан ба өөрийн үйл ажиллагаандаа ашиглаж байна.<br>ДХБ-аас гаргасан бодлогын баримт бичгийг орчуулах, албан хаагчдыг мэдээллээр хангах, гаалийн байгууллагын үйл ажиллагаанд хэрэгжүүлэх ажлын хүрээнд 4 ажлын хэсэгт орон үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэн ажилласан.<br>Олон Улсын гаалийн өдөр 2024" өдөрлөгийг зохион байгуулж ГЕГ-ын нийт албан хаагчид болон ГГХ-ыг цахимаар | 2024.01.01-2024.12.31 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | оролцуулан ДГБ-ын баярын бичгийг 20 албан хаагчид гардуулсан. Өдөрлөгийн хүрээнд бэлтгэсэн мэдээллүүдийг СЕРП системийн Гадаад арга хэмжээ талбарт байршуулсан (Хандалт: 511).<br><br>ДГБ, ДХБ, бусад олон улсын байгууллагуудтай хамтран зохион байгуулсан болон оролцсон 22 (гаалийн хяналт, шалгалт, зөрчил, барааны ангилал, гарал үүсэл, эрсдэлийн удирлагыг хэрэгжүүлэх, хамтын ажиллагаа, тариф, татвар гэх мэт чиглэлээр) арга хэмжээний баримт бичгийг боловсруулахад дэмжлэг үзүүлсэн (орчуулсан материал: 83 хуудас). | | |
| 2 | Хамтын ажиллагааны арга хэмжээг зохион байгуулсан байдал, гэрээ хэлцэл, төсөл хөтөлбөрийн хэрэгжилт | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | 1.“Гаалийн бүрдүүлэлтэд зарцуулсан цаг хугацааны судалгаа”-г 2023 онд хийсэн. Дээрх судалгааны дүнг өмнөх оны мөн үетэй харьцуулахаар нэгтгэж байна. 2.Монгол Улс, БНХАУ-ын гаалийн байгууллагын хилийн хамтарсан шалгалтын ажлын хэсгийн 10-р хуралдааныг 2023.09.07-ны өдөр цахимаар амжилттай зохион байгуулсан. Хуралдаанаар “Хяналт шалгалтын үр дүнг харилцан хүлээн зөвшөөрөх туршилтыг хэрэгжүүлэх төсөл”-ийг цаашид үргэлжлүүлэх боломжгүй учраас цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулж шинэчлэх асуудлыг судлахаар тохиролцсон. 3.БНХАУ-ын зүгээс биечлэн | Эхний хагас жилд: - Хамтын ажиллагааны арга хэмжээг (Хөрш орнууд) өндөр түвшинд зохион байгуулах гэрээ, хэлцэл, төсөл хөтөлбөр гаалийн байгууллагын үйл ажилаагаанд хэрэгжиж, үр дүнгээ өгөх.<br><br>- Гадаад худалдааны статистик зэрэгцүүлэлтийн чиглэлээр хамтын ажиллагааг үнэлж, дүгнэн, цаашдын чиглэлийг тодорхойлсон байна. | 1. Тус ажлын хүрээнд:<br><br>**ОХУ-ын ХГА-тай** цахим уулзалт - 2, Монгол Улсад- 3 уулзалт, ОХУ-д -2 уулзалтыг амжилттай зохион байгуулж цаашдын үйл ажиллагаа тохиролцсон уулзалтын тэмдэглэл байгуулсан. Чиглэлүүд:<br><br>· ИААН харилцан хүлээн зөвшөөрөх ;<br>· Эрсдэлийн удирдлагын хүрээнд хамтран ажиллах тухай;<br>· Гадаад худалдааны статистик зэрэгцүүлэлт;<br>· Гаалийн хууль сахиулах чиглэлээр<br>· Олон Улсын форум өндөр дээд хэмжээний уулзалт.<br>**БНХАУ-ын ГЕГ-тай:**<br><br>· “ИААН хөтөлбөрийг харилцан хүлээн зөвшөөрөх тухай МУ ГЕГ болон БНХАУ-ын ГЕГ хоорондын хэлэлцээр”-ийг хэрэгжүүлэх хүрээнд хятадын талтай 5 чиглэлээр санал солилцон ажилласан. | 2024.01.01-2024.12.31 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | зэрэгцүүлэлт хийх боломжгүй гэх хариуг ирүүлсэн. - БНХАУ-ын 5 боомтын зэрэгцүүлэлтийг хийсэн. 4.ОХУ-ын зүгээс биечлэн зэрэгцүүлэлт хийх боломжгүй гэх хариуг ирүүлсэн. 5.БНХАУ болон ОХУ-тай 2022 оны гадаад худалдааны статистик зэрэгцүүлэлт хийж, зөрүүний учир шалтгааныг тогтоож, зөрүү ихтэй барааны жагсаалтыг гарган, барааг сонгон тус бүрээр зөрүүний учир шалтгааныг тогтоож, танилцуулга бэлдсэн. | | · Хоёр орны гаалийн байгууллага 5 чиглэлийн уулзалтыг хоёр улсад ээлжлэн зохион байгуулахаар ГЕГ-ын дарга Р.Отгонжаргал БНХАУ-ын ГЕГ -ын даргад санал тавьсан ба тааламжтай үедээ айлчлан ирж дээрх уулзалтуудыг зохион байгуулахаар тохиролцсон.<br>2. ОХУ-тай 2024.10.02-04-ны өдрүүдэд гадаад худалдааны статистик зэрэгцүүлэлт хийж, хамтын ажиллагааг үнэлж, дүгнэн, цаашдын чиглэлийг тодорхойлсон.<br>“ИААН хөтөлбөрийг харилцан хүлээн зөвшөөрөх тухай МУ ГЕГ болон БНХАУ-ын ГЕГ хоорондын хэлэлцээр”-ийг хэрэгжүүлэх хүрээнд 5 чиглэлээр санал солилцон ажилласан. Монгол Улсын угаасан ноос, ноолуурын болон малын яс, өөх тос, ураг үйлдвэрлэлийн 17 ААН-үүдэд хятадын талтай хамтран энэ оны 6-р сард эрсдэлийн хянан магадлагаа хийсэн.<br>Мөн “Амьтан, ургамал хилээр оруулах, гаргах үеийн хорио цээрийн техникийн хамтын ажиллагааны тухай МУ-ын ГЕГ, БНХАУ-ын ГЕГ хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг”-ийг байгуулах дотоодын процесс дуусаж гарын үсэг зурхад бэлэн болгосон.<br>2. ОХУ-тай гадаад худалдааны статистик зэрэгцүүлэлт хийж, зөрүүний учир шалтгааныг тогтоосон.<br>Монгол, Хятад, Орос гурван улсын гаалийн дарга нарын 2016 “Зарим нэр төрлийн барааны хяналтын үр дүнг хүлээн зөвшөөрөх тухай хэлэлцээр”-ийг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх саналаа хөрш орнуудад илэрхийлсэн. | | |
| **Зорилт 4. “Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхыг бэхжүүлэх”** | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3 | Албан хаагчдыг уулзалт, сургалтад хамруулсан байдал, үр дүнг тооцох ажлыг зохион байгуулна. | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | Тайлант хугацаанд гаалийн байгууллагын олон талт, хоёр талт гадаад хамтын ажиллагааны хүрээнд ДГБ, ОУВС, НҮБ, АНДЭЗНК, КОЙКА, АХБ, ДХБ, ДШХ, АНУ, Япон, БНСУ, БНХАУ, ОХУ, Австрали, Тайван болон бусад орны гаалийн байгууллагатай хамтран цахим болон биет хэлбэрээр гаалийн байгууллагын 454 албан хаагчдыг уулзалт, сургалтад хамруулах, чадавхыг бэхжүүлэх чиглэлээр нийт 104 (гадаад арга хэмжээ: 85, үндэсний хэмжээний: 19) арга хэмжээ зохион байгуулсан байна. Үүнд: Гадаад: Нийт олон улсын болон бусад орны гаалийн байгууллагаас зохион байгуулсан 85 гадаад арга хэмжээнээс 55 хурал, семинар, уулзалт байсан бөгөөд 30 сургалт, чадавхыг бэхжүүлэх арга хэмжээ байна. давхардсан тоогоор 209 албан хаагчид үүнээс хүйсийн хувьд 123 буюу 60% нь эрэгтэй, 85 буюу 40% нь эмэгтэй албан хаагч нарыг хамруулсан байна. Албан тушаалын хувьд 55 буюу 26%-д нь удирдах албан тушаалтан оролцсон байна. Үндэсний хэмжээний арга хэмжээ: Гадаад хамтын ажиллагааны хүрээнд үндэсний хэмжээнд зохион байгуулсан 19 (уулзалт: 11, | Эхний хагас жилд: Албан хаагчдыг гадаадад болон гадаадын экспертүүдийн сургалтад хамруулах, сургалтын үр дүн гаалийн байгууллагын үйл ажиллагаанд хэрэгжиж үр дүнгээ өгөх. Үүнд: - Гадаад хамтын ажиллагааны хүрээнд хоёр талт болон олон талт 15 уулзалт; - Олон талт болон хоёр талт хамтын ажиллагааны хүрээнд 5 сургалт зохион байгуулах. | ДГБ, ОУВС, НҮБ, КАРЕК, АНУ, БНСУ, БНХАУ, ОХУ, Япон, Тайван, Тайланд, Швейцарь болон бусад орны гаалийн байгууллага, төсөл хөтөлбөртэй хамтран цахим болон биет хэлбэрээр нийт 94 арга хэмжээг зохион байгуулж давхардсан тоогоор 354 албан хаагч хамруулснаас ГЕГ-аас 261 (73,7%); ГГХ 93 (26,3%) албан хаагчийг хамруулсан.<br>· Эмэгтэй албан хаагч: 182 (51,4%)<br>· Эрэгтэй албан хаагч: 172 (48,6%)<br>Үүнээс удирдах албан тушаалтан 104 (29,4%).<br>Арга хэмжээний 62,7 хувь нь уулзалт, хурал (59) байсан бол 37,3 хувь нь сургалт (35) байна.<br>· Уулзалт, хурал (59): Нийт 179 албан хаагч хамрагдсанаас ГЕГ-аас 163 (90,3%); ГГХ 16 (9,7%) албан хаагч хамрагдаж эр: 94 (52,6%); эм 85 (47,4%) үүнээс удирдах албан тушаалтан 71 (39,7%).<br>· Сургалт (35): Нийт 175 албан хаагч - ГЕГ-аас 98 (56,0%); ГГХ 77 (44,0%) албан хаагч хамрагдаж эр: 78 (44,5%); эм 97 (55,5%) ба үүнээс удирдах албан тушаалтан 33 (18,8%).<br>Арга хэмжээний зохион байгуулагдсан байдлыг авч үзвэл:<br>· Гадаад (73): Нийт 174 албан хаагч (ГЕГ: 139; ГХХ:35 ба эр: 86; эм:88) оролцсоноос удирдах албан тушаалтан: 60;<br>· Монголд (19): Нийт 105 албан хаагч (ГЕГ: 99; ГХХ:6; ба эр:59; эм:46) оролцсоноос удирдах албан тушаалтан: 36;<br>· Үндэсний (2): Нийт 73 албан хаагч (ГЕГ: 21; ГХХ:52; ба эр:26; эм:47) оролцсоноос удирдах албан тушаалтан: 7;.<br>Арга хэмжээний чиглэл: | 2024.01.01-2024.12.31 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | сургалт: 8) арга хэмжээнд 230 албан хаагч (эрэгтэй: 127, эмэгтэй: 123) хамрагдсан. | | · Мэргэшлийн мэдлэгээ дээшлүүлэх - 30,2%<br>· Эдийн засгийн өрсөлдөх чадварыг бэхжүүлэх-23,1%<br>· Хууль сахиулах – 20,4%<br>· Худалдааг хөнгөвчлөх – 26,3% | | |
| 4 | Монголын гаалийн байгууллагын үйл ажиллагааг гадаад орнуудад сурталчилах, холбоо баригчийн үүрэг гүйцэтгэх ажлыг зохион байгуулсан байдал | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | ДГБ-ын дарга нарын 2023 оны 141/142 дугаар ерөнхий чуулган , ДГБ-ын Чадавхыг бэхжүүлэх хорооны ДГБ-ын 14 дүгээр хуралдаанд анх удаа оролцож Ковид цар тахалын үед ажилтанд ээлтэй ажиллах орчин бүрдүүлсэн шилдэг туршлагыг танилцуулж Монгол гаалийн байгууллагын цаашдын хөгжлийн хэрэгцээ шаардлагыг танилцуулсаны үр дүнд 2023 оны 11 сард ДГБ-ын экспертийн баг бүрэлдэхүүн ирж Ажилтанд ээлтэй орчин, стресс менежментийн сургалтыг гаалийн удирдах ажилтнуудад зориулж зохион байгуулсан. БНСУ-ын Улсын Гаалийн долоо хоног 2023 дээд хэмжээний арга хэмжээний үеэр гаалийн хэргээр хамтран ажиллаж харилцан туслалцах хэлэлцээр байгуулахаар БНХГУ-ын гаалийн байгууллагын удирдлагатай уулзаж, хоёр орны гаалийн байгууллагын хамтын ажиллагааг | Эхний хагас жилд: Монголын гаалийн байгууллагын үйл ажиллагааг гадаад орнуудад сурталчилж, гаалийн асуудлаар холбоо баригчийн үүрэг гүйцэтгэн ажиллана. | **<u>ОХУ-ын ХГА-тай</u>** холбоо баригчийн үүрэг гүйцэтгэж цаг үеийн болон тулгамдсан асуудлаар 120 гаруй цахим захидал, 85 албан бичиг солилцож, статистик мэдээ, 1103+ тээврийн хэрэгслийн мэдээлэл; ААН-үүдийн барааны экспорт, импортын гаалийн мэдүүлэг, дагалдах бичиг баримт зэрэг (1052 хуудас) мэдээллийг солилцон ажилласан.<br>**<u>БНХАУ-ын ГЕГ-тай:</u>** Хөх хотын ЗТГ, ГЕГ-ын ААН-ийн менежмент, БДШГ, ГХАХ зэрэгтэй 81+ орчим албан бичиг, ви-чат болон цахим захидлаар 420+ мэдээлэл солилцон холбоо барьж ажилласан. Үүнд:40+ гаруй ААН-ийн махны мэдээ, мал амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүний экспортын гэрчилгээ, импортын мэдэгдэл, хурал уулзалтын төлөвлөгөө болон гаалийн зөрчил, хяналт шалгалттай холбоотой бусад ажлууд.<br>АНУ, Япон, БНСУ, Узбекстан, Казахстан, Тайланд зэрэг улс орнуудтай хамтран ажиллах хүрээнд хамтын ажиллагааны төсөл хөтөлбөр, ААН-үүдийн барааны экспорт болон импортын гаалийн мэдүүлэг, дагалдах бичиг баримтын тодруулга, гаалийн зөрчил болон хяналт шалгалтын чилгэлээр 775+ албан бичиг 1750+ гаруй цахим захидал солилцож хамтран ажиллаж холбоо баригчийн үүрэг гүйцэтгэсэн.<br>ДГБ, ОУВС, НҮБ, АНДЭЗНК, КОЙКА, АХБ, КАРЕК, АНУ, Япон, БНСУ, БНХАУ, ОХУ, Австрали, Тайван болон бусад орны | 2024.01.01-2024.12.31 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хөгжүүлэх чиглэлээр тохирлцоонд хүрсэн. "Олон улсын гаалийн өдөр 2023" өдөрлөгийг цахим хэлбэрээр ДГБ-ын бодлого, чиглэл, хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр, зургийн уралдаан зэрэг 13 чиглэлээр гарын авлага, видео, постер, брошур олон нийт, гаалийн байгууллагын хамт олон, цахим, цаас, урсдаг самбар, олон нийтийн хуудсаар түгээсэн нь гаалийн байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд сурталчилж ажилласан (Хандалтын тоо: 481) үр дүнд хүрсэн. | | гаалийн байгууллагатай хамтран ажиллаж 775+ гаруй албан бичиг 1750+ цахим захидал солилцож тулгамдсан асуудал, албан хаагчдын чадавхыг бэхжүүлэх чиглэлээр тухайн улсуудад 73 хурал, уулзалт, сургалтад 174 албан хаагчыг хамруулсан. Түүнчлэн холбоо барьж ажилласаны үр дүнд:<br>- ДГБ-ын Гарал үүсэл үндэсний семинар, ОУВС-ийн "Мөнгө угаахтай тэмцэх" үндэсний семинарыг МУ-д зохион байгуулан 68 албан хаагчийн хамруулсан.<br>- ДГБ-СЕКО хамтарсан Глобал Худалдааг хөнгөвчлөх хөтөлбөрийн хоёрдугаар шатны төсөлд хамрагдахаар болсон.<br>- ДГБ-ын АНДБН-ийн гаалийн байгууллагын дарга нарын 25 дугаар хуралд ГЕГ-ын дарга оролцож бусад орны гаалийн байгууллагын дарга нартай биечлэн уулзаж монголын гаалийн байгууллагын үйл ажиллагааг сурталчилж цаашдын хамтын ажиллагааны талаар санал солилцсон.<br>- ДГБ-ын "ДГБ-ын бүс нутгийн гаалийн лабораторийн мэргэжилтэний хөтөлбөрт" хамрагдахаар болсон.<br>Австрали улсын Сидней хотноо энэ оны 04 дүгээр сард зохион байгуулагдсан ДГБ-ын АНДБН-ийн Гаалийн байгууллагын дарга нарын ээлжит уулзалтаар Тайландын Хаант Улсын гаалийн байгууллагатай "Гаалийн асуудлаар хамтран ажиллах, харилцан туслах тухай хэлэлцээрийг байгуулсан. | | |
| 5 | Гаалийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой гадаад бичиг баримт | Хэрэгжилт, гүйцэтгэлэр | Гадаад хамтын ажиллагааны хүрээнд үндэсний хэмжээнд зохион байгуулсан 19 (уулзалт: 11, сургалт: 8) арга хэмжээнд 230 албан хаагч хамрагдсан.Тус сургалт | Эхний хагас жилд: Гаалийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой гадаад бичиг баримт орчуулж, гадаад | Монгол Улсад 21 арга хэмжээ зохион байгуулсан. Тус арга хэмжээнүүдэд албан ёсны орчуулга хийхийн сацуу Гадаад хамтын ажиллагаатай холбоотой гадаад бичиг баримтыг орчуулан ажилласан. Үүнээс 19 уулзалт, үндэсний хэмжээний 2 сургалт зохион байгуулж 178 албан хаагч | 2024.01.01-2024.12.31 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | орчуулж, гадаад хурал, арга хэмжээнд албан ёсны орчуулга хийх ажлыг зохион байгуулсан байдал | | уулзалтуудад орчуулга хийн амжилттай зохион байгуулсан. | хурал, арга хэмжээнд албан ёсны орчуулга хийх ажлыг зохион байгуулж, орчуулгын талаар оновчтой тайлагнах. | хамруулсан (Орчуулсан материал: 53 презинтаци, 292 гаруй хуудас материал: хурал даргалагчийн үг, ярианы сэдэв, уулзалтын тэмдэглэл, протокол г.м). Үүнд:<br>· Уулзалт (19): ОХУ-ын ХГА-тай- 5 (ИААН, Эрсдэлийн удирдлага, Статистик зэрэгцүүлэлт, хууль сахиулах 7-р уулзалт, РРТ ашиглан мэдээлэл солилцох зэрэг – 71 хууд); НҮБ-тай -1 (Хар тамхи, гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлийн уулзалт); АНУ-ын ЭСЯ, атташе бусад байгууллагуудтай ГЕГ-ын даргын хийсэн уулзалт – 4 (Хар тамхитай тэмцэх, чингэлэг хяналт; Лабораторын тоног төхөөрөмж; загас, зэрлэг ан амьтдын хамгааллын асуудал; оюуны өмч); БНТУ-ын ЭСЯ-тай – 2 (хамтын ажиллагаа); ДГБ-тай -2 (Гарал үүслийн семинар, Синтетик бодистой тэмцэх уулзалт); ИТС -1 (Худалдаа, хөрөнгө оруулалтын болон дэд хорооны 6-р уулзалт); БНСУ-тай-1 (Эрэлч нохойн хамтын ажиллагаа); БНХАУ-тай-2 (Хорио цээр, амьтан ургамал); Карек -1 (ИААН-ийн хөтөлбөр).<br>· Сургалт (2): ОУВС-тай -2 (Азийн гаалийн байгууллагын шинэчлэлийн хөтөлбөр; "Мөнгө угаахтай тэмцэх" үндэсний семинар);<br>Түүнчлэн томоохон үр дүнгээс дурдвал (1 хэлэлцээр байгуулж 2 хэлэлцээр, 3 санамж бичгийг гарын үсэг зурах түвшинд хүргэсэн).<br>Австрали улсын Сидней хотноо энэ оны 04 дүгээр сард зохион байгуулагдсан ДГБ-ын АНДБН-ийн Гаалийн байгууллагын дарга нарын ээлжит уулзалтаар Тайландын Хаант Улсын гаалийн байгууллагатай "Гаалийн асуудлаар хамтран ажиллах, харилцан туслах тухай хэлэлцээрийг байгуулсан. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Мөн Узбекстан Улсын болон Катар Улсын гаалийн байгууллагуутай “Гаалийн асуудлаар хамтран ажиллах, харилцан туслах тухай хэлэлцээр” БНСУ-ын KTNET, SECO хамтын ажиллагааны санамж бичгүүдийг байгуулахаар боловсруулан байгуулахад бэлэн болгосон.<br>БНХАУ-ын ГЕГ-тай “Амьтан, ургамал хилээр оруулах, гаргах үеийн хорио цээрийн техникийн хамтын ажиллагааны тухай Монгол Улсын ГЕГ, БНХАУ-ын ГЕГ хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг”-ийг байгуулах дотоодын процесс дууссаж гарын үсэг зурхад бэлэн болсон. | | |
| 6 | ДГБ бусад олон улсын байгуулагтай хамран ажиллаж, гаалийн байгуулагын чадавхыг бэхжүүлэхэд олон улсын тэргүүн туршлага, арга хэрэгслийг судалж санал, зөвлөмж боловсруулах, үйл ажилаагаандаа нэвтрүүлэх ажлыг зохион байгуулсан байдал | Хэрэгжилт, гүйцэтгэлэр | Тайлант хугацаанд гаалийн байгууллагын олон талт, хоёр талт гадаад хамтын ажиллагааны хүрээнд ДГБ, ОУВС, НҮБ, АНДЭЗНК, КОЙКА, АХБ, ДХБ, ДШХ, АНУ, Япон, БНСУ, БНХАУ, ОХУ, Австрали, Тайван болон бусад орны гаалийн байгууллагатай хамтран цахим болон биет хэлбэрээр гаалийн байгууллагын 454 албан хаагчдыг уулзалт, сургалтад хамруулах, чадавхыг бэхжүүлэх чиглэлээр нийт 104 (гадаад арга хэмжээ: 85, үндэсний хэмжээний: 19) арга хэмжээ зохион байгуулсан. | Эхний хагас жилд: ДГБ болон бусад олон улсын байгууллагатай (ДГБ, НҮБ, ОУВС, Их түмэн санаачилга, КАРЕК гэх мэт) хамтран ажиллаж, гаалийн байгууллагын чадавхыг бэхжүүлэхэд олон улсын тэргүүн туршлага, арга хэрэгслийг судалж санал, зөвлөмж боловсруулах, үйл ажилаагаандаа нэвтрүүлэх ажлыг зохион байгуулна | ДГБ бусад олон улсын байгуулагатай хамран ажиллаж, гаалийн байгуулагын чадавхыг бэхжүүлэх хүрээнд “Олон улсын гаалийн өдөр 2024” өдөрлөгийг цахим хэлбэрээр амжилттай тэмдэглэн өнгөрүүлсэн. Энэ нь ДГБ-ын бодлого, чиглэл, хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр, зургийн уралдаан зэрэг 10 чиглэлээр цахим гарын авлага, видео, постер, брошуроор гаалийн байгууллагын хамт олонд, цахим, цаас, олон нийтийн хуудсаар түгээж, ДГБ-ын зөвлөмж, тэргүүн туршлагыг албан хаагчдад үйл ажиллагаандаа нэвтрүүлэхэд дэмжлэг болсон.<br>Түүнчлэн ДГБ, ОУВС, НҮБ, КАРЕК, АНУ, БНСУ, БНХАУ, ОХУ, Япон болон бусад орны гаалийн байгууллага, төсөл хөтөлбөртэй хамтран албан хаагчдын мэргэшлийн мэдлэгийг дээшлүүлэх, олон улсын тэргүүн туршлагыг судлуулах зорилгоор цахим болон биет хэлбэрээр нийт 75 арга хэмжээг (гадаад улсад 73: 174 албан хаагч; үндэсний 2: 73 албан хаагч) зохион байгуулж 247 албан хаагч хамруулсан.<br>Олон улсын тэргүүн туршлага, арга хэрэгслийг судалж санал, зөвлөмж | 2024.01.01-2024.12.31 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | боловсруулах, үйл ажилаагаандаа нэвтрүүлэх зорилгоор 73 гадаад арга хэмжээнд оролцсон 174 албан хаагчдийн тайлан болон ДГБ, бусад олон улсын байгуулагын төсөл хөтөлбөрийн мэдээллийг ЗДС СЕРП програмаар түгээсэн (Хандалт: 3022). | | |
| 7 | Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилт | Хэрэгжилт, гүйцэтгэлэ эр | Гаалийн байгууллагын гадаад хамтын ажиллагааны чиглэлээр ДГБ болон бусад олон улсын байгууллагын гэрээ, конвенцийн хэрэгжилт бусад орны гаалийн байгууллагатай гаалийн асуудлаар хамтран ажиллах, харилцан туслалцах Засгийн газрын хэлэлцээрт үндэслэн гаалийн асуудлаар мэдээлэл солилцож, хамтын ажиллагааг хөгжүүлж ажиллсан. Гаалийн хяналт шалгалтын чиглэлээр ДГБ-аас зохион байгуулж байгаа цахим болон биет хурал, семинар, БНХАУ болон ОХУ-ын БНСУ-ын гаалийн байгууллагын дарга нарын уулзалт, хөрш орны гаалийн байгууллагатай хамтарсан хяналт шалгалтын ажлын хэсгийн ээлжит хуралдаан, хилийн холбоо баригч дарга нарын уулзалт, статистик мэдээлэл солилцох ажлын хэсгийн уулзалтыг зохион байгуулж нийт 18 протокол, санамж бичиг байгуулж ажилласан байна | Эхний хагас жилд : Нэгжийн чиг үүргийн хүрээнд "Гаалийн байгууллагын үйл ажиллагаанд хяналтшинжилгээ хийх, үр дүнг үнэлэх аргачлал"-д заасан бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангаж, тайлагнасан байна. | ГЕГ-ын 2021-2024 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө, 2024 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөө болон ГЕГ-ын даргын 2024 оны А/190 дугаар тушаалын 1.10 дугаар хавсралтаар баталсан 12 шалгуур үзүүлэлтийн дагуу тухай бүр тайлагнасан. Мөн тушаалын 2.5.8-ийн дагуу гадаад улсад зохион байгуулагдсан 62 хурал, уулзалт, сургалтад зохион байгуулагч талын зардлын тусламжаар 207 албан хаагчыг хамруулсан.<br>Түүнчлэн А/190 дүгээр тушаалын дагуу байгууллагын үйл ажиллагааны ил тод нээлттэй байдлыг хангах хүрээнд тус нэгжийн үйл ажиллагаанд хамаарах 25 мэдээллийг Гаалийн байгууллагын цахим хуудасаар дамжуулан олны хүртээл болгон, байгууллагын ил тод, нээлттэй байдлыг хангаан ажиллахад дэмжлэг үзүүлсэн.<br>Гаалийн ерөнхий газрын даргын 2016 оны А/69 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан "Гаалийн улсын байцаагчийн үйлчилгээний стандарт", 2021 оны А/251 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан "Гаалийн улсын байцаагчийн дүрэмт хувцас, ялгах тэмдгийг хэрэглэх журам"-ыг тус хэлтсийн албан хаагчид танилцаж 46 дугаартай дотоод зурвасаар ЗУГ-т хүргүүлсэн.<br>ДГБ болон бусад олон улсын байгууллагын гэрээ, конвенцийн хэрэгжилт бусад орны гаалийн байгууллагатай гаалийн асуудлаар хамтран ажиллах, харилцан туслалцах Засгийн газрын хэлэлцээрт үндэслэн | 2024.01.01-2024.12.31 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | гаалийн асуудлаар мэдээлэл солилцож, хамтын ажиллагааг хөгжүүлж ажиллсан (1750+ гаруй цахим захидал солилцсон). | | |
| 8 | Хууль тогтоомж, эрх зүйн актын хэрэгжилт | Хэрэгжилт, гүйцэтгэлэ эр | Гаалийн хяналт шалгалтын үндсэн олон улсын конвенци болох шинэчлэн найруулсан Киото конвенцийн сүүлийн үеийн шинэчлэлийн талаар мэдлэг, мэдээллээр хангах зорилготой Дэлхийн гаалийн байгууллагын "Шинэчлэн найруулсан Киото Конвенцийн Бүс нутгийн сургалт-д гаалийн 3 албан хаагчийн оролцоог хангаж ажилласан. Дэлхийн Худалдааны байгууллагын Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийн хэрэгжилтийн тайлан гаргаж, тухай бүр Гадаад харилцааны яаманд хүргэж ажилласан. Хөрш орны гаалийн байгууллагатай гаалийн хяналт шалгалтын асуудлаар хамтын ажиллагаа хөгжүүлэх асуудлаар уулзалт, хурлыг зохион байгуулж, 20 орчим протокол, санамж бичиг ббайгуулан ажиллаж, түүний хэрэгжилтийг хангаж ажилласан. Үүнээс БНХАУ-ын гаалийн байгууллагатай 14 хурлын протокол, санамж бичиг, ОХУын ХГА-тай 6 бичиг баримтад боловсруулж, хэрэгжилтийг хангаж ажилласан. | Эхний хагас жилд: Нэгжийн чиг үүргийн хүрээнд "Гаалийн байгууллагын үйл ажиллагаанд хяналтшинжилгээ хийх, үр дүнг үнэлэх аргачлал"-д заасан бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангаж, тайлагнасан байна. | Тайлант хугацаанд ГЕГ-ын 2021-2024 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө, 2024 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөө болон ГЕГ-ын даргын 2024 оны А/190 дугаар тушаалын 1.10 дугаар хавсралтаар баталсан 12 шалгуур үзүүлэлтийн дагуу үйл ажиллагаагаа төлөвлөн хэрэгжилтийг хангаж заасан хугацаанд хагас жилээр болон бүтэн жилээр гарган CERP системээр илгээж тайлагнасан.<br>ХАСХОМ-ыг 2024 оны тайланг хуулийн хугацаанд ажиллаж байсан 2 албан хаагч холбогдох баталгааны маягтын дагуу гарган ХНХ-т хүлээлгэн өгч, 100 хувь баталгаажуулсан. ХАСУМ-ийг шилжин, болон томилогдсон 4 албан хаагч мэдүүлж баталгаажуулсан.<br>Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай" хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд тус хэлтсийн чиг үүргийн хүрээнд нийт 279 гадаад, 91 дотоод албан бичиг, 230 дотоод зурвасыг хүлээн авч, нийт 600 бичгийг хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэсэн. Энэ нь мөн онтой харьцуулвал 12,3% илүү албан бичгийг шийдвэрлэсэн байна.<br>БНСУ-тай байгуулах Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийг байгуулах 4-р шатны хэлэлцээ хийх хүрээнд "Барааны гарал, үүслийн дүрмийн бүлгийн ажлын хэсэгт орж ажилласан.<br>Бахман компанитай байгуулсан Гэрээг шинэчлэх хүрээнд ажлын хэсэгт орж ажилласан. | 2024.01.01-2024.12.31 | |
| 9 | Нэгжийн эрсдэлийн удирдлагыг | Хэрэгжилт, гүйцэтгэлэ эр | Нэгжийн үйл ажиллагаанд эрсдэл тооцож ажилласан. | Эхний хагас жилд: - Нэгжийн эрсдэлийг | 1. Тайлант хугацаанд тус хэлтэст ажиллавал зохих 8 албан хаагчаас 3 орон тоо дутуу бөгөөд ГУАБ болон 1 ГУБ | 2024.01.01-2024.12.31 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хэрэгжүүлсэн байдал | | Өмнөх онд тайлагнаж байгаагүй. | таньж тогтоож, сан үүсгэнэ.<br><br>- Эрсдэлийн дүн шинжилгээ хийж, бууруулах арга хэмжээ авч тайлагнана | хүүхэд асрах ээлжийн чөлөөтэй, 1 албан хаагч ЗҮГГ-т шилжсэн. Үүнтэй холбогдуулан ажлын шаардлагаар СЭГГ-ын ГУБ Ө.Намуунбайгалыг тус хэлтэст I дүгээр улиралд түр хугацаагаар ажиллуулан II дугаар улирлаас тус хэлтэст жинхэлсэн. Түүнчлэн ГЕГ-аас зарласан тусгай сонгон шалгалтаар 3 албан хаагч нэмэгдсэнээр тайлант хугацаанд нийт 6 албан хаагч ажилласан. Нэгжийн гүйцэтгэлийг давхардалгүй, орхигдуулахгүй, үр дүнтэй зохион байгуулахад учирч болзошгүй эрсдэлийг таньж, тогтоон түүнийг бууруулах арга хэмжээг зохион байгуулан хэрэгжүүлэх зорилгоор судалгаа хийж нэгжийн эрсдэлийн сан үүсгэсэн.<br>Санд доорх хэсгийг тусгасан:<br>- Хэлтсийн үндсэн үүрэг, чиг үүргийн харьцуулалт;<br>- Үндсэн ажлаас гадуур болон цаг үеийн шинжтэй гүйцэтгэсэн ажлыг тайлагнах;<br>- Ажиллаж байсан, одоо ажиллаж байгаа албан хаагчдын үндсэн мэргэжил, ур чадвар, гүйцэтгэл, ажлын цаг ашиглалт, илүү цаг болон бусад дотоод ажлыг хөгжүүлэх;<br>- Гүйцэтгэлийн тайлан, ХШҮДАГ-аас ирүүлсэн зөвлөмж, удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг цаг тухайд нь гүйцэтгэх;<br>Төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, гадаад орны гаалийн байгууллагатай хамтын ажиллагааг хөгжүүлэх.<br>2. Эрсдэлийн дүн шинжилгээ хийж, бууруулах арга хэмжээний хүрээнд дараах арга хэмжээг авсан:<br>Нэгжийн эрсдэлийг таньж тогтоох сан үүсгэсэн. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Хүний нөөц, бүтэц, зохион байгуулалтад мониторнг хийсэн;<br>Сүүлийн 3 жилд ажлын холбогдолтой үүссэн эрсдэлийг таньж тогтоосон;<br>Ганцаарчилсан болон фокус ярилцлага хийсэн, Цаашдын үр ашиг, үр нөлөөг дээшлүүлэхийн тулд хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг гаргасан. | | |
| 10 | Үүрэг даалгаврын биелэлт | Хэрэгжилт, гүйцэтгэлэ эр | Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг тухай бүр хангаж ажиллаж, тайлагнасан. Нэгжийн 2023 оны үнэлгээ 5. | Эхний хагас жилд: - Өгөгдсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь бүрэн биелүүлж ажилласан байна. - Бусдад хүргүүлсэн үүрэг даалгаврын биелэлтийг хугацаанд нь дүгнэж, ЗДАС программд үнэлсэн байна. | Тайлант хугацаанд гадаад: 279 дотоод: 91 албан бичиг хүлээн авч ЗББНДБ-д 230 дотоод зурвас хүргүүлж 371 дотоод зурвасын хүлээн авч хуулийн дагуу шийдвэрлэсэн.<br>Удирдлагаас ЗДАС программаар ирүүлсэн 13 үүрэг даалгавар, зөвлөмжийн биелэлтийг цаг хугацаанд нь хэрэгжүүлж тухай бүр тайлагнан ажилласан. Өгөрсөн оны мөн үетэй харьцуулвал 7 үүрэг даалгавараар илүү байсан.<br>Түүнчлэн шуурхай онлайн хурлаас өгсөн 3 үүрэг даалгаврыг биелүүлсэн. Үүнд:<br>· ГЕГ-ын даргын 2016 оны А/69 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Гаалийн улсын байцаагчийн үйлчилгээний стандарт”, 2021 оны А/251 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Гаалийн улсын байцаагчийн дүрэмт хувцас, ялгах тэмдгийг хэрэглэх журам”-ыг нийт албан хаагчиддаа танилцуулсан. ЗУГ-т 46 тоот дотоод зурвасаар хариу хүргүүлсэн.<br>· Гаалийн ерөнхий газрын даргын 2021 оны А/251 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Гаалийн улсын байцаагчийн дүрэмт хувцас, ялгах тэмдэг хэрэглэх журам”-ын хэрэгжилтийг хангаж, журмын дагуу өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавьж ажилласан.<br>· 7 хоногийн онцлог ажлын тайланг ЗУГ-т тухай бүр хүргүүлэн ажилласан. | 2024.01.01-2024.12.31 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Үүрэг даалгаварын биелэлт 100 хувь. Тайлант хугацаанд тус нэгжээс ЗДАС программаар өгсөн үүрэг даалгавар байхгүй. | | |
| 11 | Ажлын цаг ашиглалт | Хэрэгжилт, гүйцэтгэлээр, хувиар | Нэгжийн албан хаагчдын цаг ашиглалтын хэвийн үйл ажиллагааг хангасан байна. Нэгжийн 2023 оны үнэлгээ 4.5. | Эхний хагас жилд : Ажлын цаг ашиглалт суурь түвшнээс сайжирсан байна. | Тайлант хугацаанд тус хэлтэст ажиллавал зохих 8 албан хаагчаас 3 орон тоо дутуу бөгөөд ГУАБ болон 1 ГУБ хүүхэд асрах ээлжийн чөлөөтэй, 1 албан хаагч ЗҮГГ-т шилжсэн. Үүнтэй холбогдуулан ажлын шаардлагаар СЭГГ-ын ГУБ Ө.Намуунбайгалыг тус хэлтэст I дүгээр улиралд түр хугацаагаар ажиллуулан II дугаар улирлаас тус хэлтэст жинхэлсэн. Түүнчлэн ГЕГ-аас зарласан тусгай сонгон шалгалтаар 3 албан хаагч нэмэгдсэнээр тайлант хугацаанд нийт 6 албан хаагч ажилласан. Өмнөх оны ажлын цаг ашиглалт 90 хувь байсан. Энэ нь гадаад хамтын ажиллагаа цахим хэлбэрт шилжин, албан хаагч нар цагийн зөрүүтэй байдлаар ажилласантай холбоотой.<br>Тайлант хугацаанд ажлын шаардлагаар түр хугацаагаар ажилласан албан хаагч болон ээлжийн амралтын хоногийг хасвал, ажиллавал зохих 1213 хүн өдрөөс ажилласан 1157 хүн өдөр буюу ажлын цаг ашиглалт 95,4 % байна.<br>Дарга Ө.Цолмон – 238 (э/амралт:15 хоног); ГУАБ – Х.Мөнхзул -103 (5 сарын 27-ноос э/амралт хүүхэд асрах чөлөө авсан); ГУБ Д.Баярсайхан – 224 (э/амралт:29 хоног); ГУБ Ц.Даваасүрэн – 43 (3 сарын 1-нээс шилжсэн); ГУБ Ө.Намуунбайгал – 138 (5 сарын 1-нээс томилогдсон, э/амралт:18 хоног, 12/09-24 эрүүл мэндийн чөлөө 12 хоног); ГУБ Э.Энхтуяа – 201 (3 сарын 14-нээс томилогдсон); ГУБ Б.Ундрал – 127 (7 сарын 1-нээс томилогдсон); ГУБ Я.Оюумаа - 83 (7 сарын 1-нээс томилогдсон, сургалтын чөлөө (44): 7/16- | 2024.01.01-2024.12.31 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 26-ны хооронд 9; 11/20-он дуустал 35 хоног).<br>Ажиллавал зохих 1213 хүн өдрөөс ажилласан 1157 хүн өдөр буюу ажлын цаг ашиглалт 95,4 % байна.<br>Ажлын цаг ашиглалтад илүү цагаар ажилласан хугацааг оруулаагүй бөгөөд тайлант хугацаанд 8 албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг 6 албан хаагч биелүүлж байгаа ажлын ачаалал, үр дүнтэй харьцуулвал ажлын цаг ашиглалт 100 хувь байна. | | |
| 12 | Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт | Хэрэгжилт, гүйцэтгэлэр | 1. Гаалийн байгууллагын цаг үеийн шинжтэй ОХУ-ын орлогч даргын айлчлал, ОХУ-тай хийсэн гаалийн зөрчилтэй тэмцэх зургаадугаар уулзалт, ОУВС-ын сургалт, уулзалтууд, Замын-Үүд-Эрээний авто замын боомтын мэдээлэл, Унгар Улстай хийсэн уулзалт, Их түмэн санаачилгын "Худалдаа, хөрөнгө оруулалт", "Гаалийн дэд хороо"-ны 5 дугаар хуралдаан, НҮБ-ын АНДЭЗНК Их түмэн санаачилгын хамтарсан "Худалдааг хөнгөвчлөх" олон улсын семинар зэрэг цаг үеийн шинжтэй 15 мэдээллийг Гаалийн байгууллагын цахим хуудасаар дамжуулан олны хүртээл болгон, байгууллагын ил тод, нээлттэй байдлыг хангаж ажиллахад дэмжлэг үзүүлсэн. 2. НҮБ-ын Дэлхийн судалгаа дижитал болон тогтвортой худалдаа | Эхний хагас жилд : Гаалийн байгууллагын цаг үеийн шинжтэй 10 мэдээллийг бэлтгэн (англи, монгол хэлнээ хөрвүүлэх), цахим хуудаст нийтлэн олны хүртээл болгох ба гаалийн чиг үүрэгтэй холбоотой санал асуулга, холбогдох судалгаанд хариу хүргүүлэн ажилласан байна. | Гаалийн байгууллагын цаг үеийн шинжтэй 10 мэдээллийг Гаалийн байгууллагын цахим хуудасаар дамжуулан олны хүртээл болгон, байгууллагын ил тод, нээлттэй байдлыг хангаж ажиллахад дэмжлэг үзүүлсэн.<br>ИТС-ын, ОУВС, ДГБ-ын 3 төрлийн төсөлд монголын гаалийн байгууллагын саналыг тусгаж хүргүүлсэн (20 хуудас).<br>ГЕГ-ын албан хаагчдын ажил байдлын тодорхойлолтыг 70 албан хаагчдад гаргаж өгч гадаад улсын ЭСЯ-нд хүргүүлсэн.<br>5 ажлын хэсэгт орсон:<br>- ГЕГ-аас олгогддог мал амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүний экспортын гэрчилгээ, импортын мэдэгдлийг Мал эмнэлгийн ерөнхий газраас олгох болсонтой холбогдуулан байгуулах ажлын хэсэг;<br>- ДХБ-ын Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийн хэрэгжилтийг хангах, Худалдааг хөнгөвчлөх үндэсний хорооны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий ажлын хэсэг;<br>- НҮБ-ын Худалдаа Хөгжлийн бага хурлын төслийн багтай хамтран өнөөгийн нөхцөл байдлын судалгаа хийх, төслийн хүрээнд хүлээгдэж буй үр дүн, үр ашгийг тодорхойлох гаалийн байгууллагын үйл ажиллагаатай | 2024.01.01-2024.12.31 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хөгжүүлэх 2023 оны судалгаа (48 хуудас), ДГБ-ын гаалийн байгууллагын судалгаа (50 хуудас), Ази, Номхон Далайн Бүс нутгийн Чадавхыг Бэхжүүлэх Төвөөс 2022/2023 онд тус байгууллагаас авах техникийн туслалцаа (20 хуудас) 3 төрлийн санал асуулгыг холбогдох нэгжээс мэдээлэл авч, боловсруулан орчуулж хүргүүлсэн (Нийт 118 хуудас). | | уялдуулахад дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий ажлын хэсэг;<br>- Монгол Улс, БНСУ хоорондын Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр байгуулах ажлын хэсэг<br>- "Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн төсөл (RIBS)"-ийн хүрээнд "Хилийн зохицуулалттай менежмент" сэдвийн хүрээнд сургалтын жишиг хөтөлбөрийг боловсруулах ажлын хэсэг;<br>Гаалийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 34 лавлагаа, хүсэлтэд гаалийн хууль тогтоомжийн хүрээнд болон чиглэл хариуцсан нэгжээс мэдээлэл авч тухай бүр хүргүүлэн ажилласан. | | |

## Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин | Эхэлсэн дууссан хугацаа | Биелэл ийн ху |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1 | Төрийн албаны тухай хуулийн 29.1-т заасан богино болон дунд хугацааны сургалтад хамрагдах | Хэрэгжилт, гүйцэтгэлээр, сургалтын тоогоор | Гадаад хэл дээрх мэдээллийн эх сурвалжийг харьцуулан судлаж удирдлагаас өгсөн үүрэг даалгаварыг цаг хугацаанд нь биелүүлсэн. | Богино болон дунд хугацааны сургалтад хамрагдсан байна. | 2024 оны эхний хагас жилд Төрийн албаны тухай хуулийн 29.1-т заасан богино болон дунд хугацааны сургалтад хамрагдах арга хэмжээний хүрээнд дараах 3 сургалт, семинарт хамрагдаж, мэдлэг ур чадвараа дээшлүүлсэн.Үүнд:<br>- КАРЕК хөтөлбөрийн хүрээнд гишүүн орнуудад зориулсан худалдаа, хөрөнгө оруулалтын семинарт;<br>- ОУВС-ийн "Мөнгө угаахтай тэмцэх" асуудлаар зохион байгуулж буй үндэсний сургалт-семинарт;<br>ДГБ-ын Гарал үүсэл үндэсний сургалт-семинар. | 2024.01.01-2024.12.31 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2 | Гадаад хэл дээрх мэдээллийн эх сурвалжийг харьцуулан судлана. | Хэрэгжилт, гүйцэтгэлээр, | Англи хэлийг бие даан суралцаж, гаалийн хэргийн мэдлэгээ дээшлүүлсэн. | Гаалийн байгууллагын гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэхэд дэмжлэг болж, хэлтсийн албан хаагч нарыг мэргэжил, арга зүйн зөвлөмжөөр ханган ажилласан байна. | Гаалийн хөгжлийн чиг хандлагаас суралцаж, дэлхий нийттэй хөл нийлүүлэн алхахын тулд ДГБ-ын вебсайт https://www.wcoomd.org/ болон фэйсбүүк пэйж хуудсаар тогтмол зочилж сүүлийн үеийн мэдээ, мэдээлэлтэй байнга танилцаж өдөр тутмын үйл ажиллагаандаа ашиглаж, хэлтсийн албан хаагч нарыг мэргэжил, арга зүйн зөвлөмжөөр ханган.<br>ДГБ, ОУВС, НҮБ, КАРЕК, АНУ, БНСУ, БНХАУ, ОХУ, Япон болон бусад орны гаалийн байгууллага, төсөл хөтөлбөртэй хамтран ажиллах хүрээнд гадаад хэл дээрх мэдээллийг харьцуулан судлаж цахим болон биет хэлбэрээр нийт 45 арга хэмжээ зохион байгуулсан.<br>Түүнчлэн Узбекистантай байгуулах “Гаалийн асуудлаар хамтран ажиллах, харилцан туслах тухай Бүгд Найрамдах Узбекистан Улсын Засгийн Газар болон Монгол Улсын Засгийн Газар хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг”-ийн төслийг англи хэлнээс монгол хэл рүү орчуулж, танилцуулга бичиж, ГЕГ-ын бүтцийн нэгжүүдэд хүргүүлсэн. | 2024.01.01-2024.12.31 | |

**ТАЙЛАН ГАРГАСАН:**

Гадаад хамтын
ажиллагааны хэлтсийн дарга.................... / Ө.ЦОЛМОН / 2024 . 12 . 10.

*(Албан тушаал)* *(Нэр, гарын үсэг)* *(Огноо)*

# ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХЭЛТСИЙН ДАРГА ӨЛЗИЙДҮҮРЭНГИЙН ЦОЛМОНГИЙН 2024 ОНЫ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Байгууллагын нэр: Гаалийн ерөнхий газар
Нэгжийн нэр: Гадаад хамтын ажиллагааны хэлтэс

## 1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ | Гүйцэтгэлийн түвшин | Нийт оноо (70 оноо) |
|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 |
| 1 | Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт | | 61.74 |

## 2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний биелэлтийн хувь | Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор) |
|---|---|---|---|
| 1 | Төрийн албаны тухай хуулийн 29.1-т заасан богино болон дунд хугацааны сургалтад хамрагдах | | 14.5 |
| 2 | Англи хэлний мэдлэгээ дээшлүүлэх | | 14.5 |
| | **Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний дундаж оноо** | | 14.5 |

## 3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ

| Д/д | Үзүүлэлт | Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор) |
|---|---|---|
| 1 | Хандлага, ёс зүй | 14 |
| 2 | Удирдан зохион байгуулах | 10 |
| 3 | Асуудал шийдвэрлэх | 12 |
| 4 | Манлайлах | 12 |
| 5 | Багаар ажиллах | 13 |
| 6 | Харилцаа | 15 |
| | Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан) | |
| 7 | Мэргэжлийн ур чадвар | – |
| | **Хандлага, ёс зүй, ур чадварын дундаж оноо** | 12.67 |

## 4. Гүйцэтгэлийн үнэлгээ

| Д/д | Үнэлгээний үзүүлэлт | Үзүүлэлт тус бүрийн оноо |
|---|---|---|
| 1 | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт | 61.74 |
| 2 | Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт | 14.5 |
| 3 | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ | 12.67 |

| | | |
|---|---|---|
| | | |
| **Нийт оноо=**<br>(Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо+Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо+Хандлага, ёс зүй, ур чадварын оноо) – Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо | | 88.9 |

**Үнэлгээ өгсөн:**

Гаалийн ерөнхий газрын дарга

**Төсвийн шууд захирагч**

.......................... (Р.Отгонжаргал)

2024.12.19 (огноо)

**Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:**

/Гадаад хамтын ажиллагааны хэлтэсийн дарга/

**Нэгжийн дарга:**

.......................... (Ө. Цолмон)

2024.12.20 (огноо)